

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: [atartsetsegm@audit.gov.mn](mailto:atartsetsegm@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.24 № 77

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Хувьчлах хөрөнгийн орлогын төлөвлөгөөг 150.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 5,831.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 7,206.7 мянган төгрөгийн хөрөнгийг худалдаж, 10,900.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 21,345.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 7 зорилт, 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 49 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлснээр тайлагнасан бөгөөд аймгийн Засаг дарга үнэлээгүй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

. 07020164

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	42,794.93	42,692.93
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	177,594.47	158,937.82
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>220,389.39</b>	<b>201,630.75</b>
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	220,389.39	201,630.75
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>220,389.39</b>	<b>201,630.75</b>
Үйл ажиллагааны орлогын дүн	264,273.44	333,614.51
Үйл ажиллагааны зардлын дүн	268,588.70	341,605.53
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(4,315.26)</b>	<b>(7,991.02)</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	61,770.45	10,767.62
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(66,085.71)</b>	<b>(18,758.64)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	286,475.11	220,389.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Тайлант оны үр дүн	(66,085.71)	(18,758.64)
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>220,389.39</b>	<b>201,630.75</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	256,178.40	327,783.51
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	256,178.40	327,783.51
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>254,678.40</b>	<b>315,877.20</b>
Урсгал зардал	254,678.40	315,877.20
Хөрөнгийн зардал	-	-
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>254,678.40</b>	<b>315,877.20</b>
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	245,683.40	314,967.20
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	8,995.00	910.00

## Гурав. Аудитын илрүүлэлт:

### Аудитын илрүүлэлт

Аудитаар 1,200.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

#### Залруулсан алдаа

- **Хуультай холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 1,200.0 мянган төгрөгийг нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 1,332.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,332.4 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрч төлбөрийн 2 акт тогтоосон.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 338.4 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын амралтын цалинтай давхардуулан олгосон цалинг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

2. Ажилчдад 1 өдрийн 994.0 мянган төгрөгийн томилолт илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдад илүү олгосон томилолтын мөнгийг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
										тоо	Дүн	тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	6,000.0	-	-	1.00	6,000.0	1	6,000.0	-	-	-	-
Дүн		1	6,000.0	0	-	1	6,000.0	1	6,000.0	0	-	-	-

#### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Цалингийн зардлын төсвөөс эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 1,932.0 мянган төгрөгийг зарцуулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын даргын шийдвэрээр төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин нэмэгдүүлсэн.	1	1,932.0	-	-	1	1,932.0	-	-	-	-
Нийт		2	1,932.0	-	-	2	1,932.0	-	-	-	-

Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Тайлант онд 20,103.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.	1	20,103.1	-	-	1	20,103.1	-	-
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>20,103.1</b>	-	-	<b>1</b>	<b>20,103.1</b>	-	-